

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагааннуур тохижилт ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/18-НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он	<table><tr><td>Тэргүүлэх аудитор:</td><td>Ч.Энхтуяа</td></tr><tr><td>Утас:7036-3040</td><td>Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn</td></tr><tr><td>Аудитын менежер:</td><td>Б.Батмөнх</td></tr><tr><td>Утас: 7036-3036</td><td>Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn</td></tr><tr><td>Аудитор:</td><td>Т.Одсүрэн</td></tr><tr><td>Утас: 7036-2442</td><td>Цахим хаяг: odsurent@audit.gov.com</td></tr></table>	Тэргүүлэх аудитор:	Ч.Энхтуяа	Утас:7036-3040	Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn	Аудитын менежер:	Б.Батмөнх	Утас: 7036-3036	Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn	Аудитор:	Т.Одсүрэн	Утас: 7036-2442	Цахим хаяг: odsurent@audit.gov.com
Тэргүүлэх аудитор:	Ч.Энхтуяа												
Утас:7036-3040	Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn												
Аудитын менежер:	Б.Батмөнх												
Утас: 7036-3036	Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn												
Аудитор:	Т.Одсүрэн												
Утас: 7036-2442	Цахим хаяг: odsurent@audit.gov.com												

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

СЭА-2022/18-НА-СТА-ОНА

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	8
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	9
4. Аудитын тайлан.....	10
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Дотод хяналт	11
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
4.4 Материаллаг байдал	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
5.1 Шилэн дансны мэдээлэл	12
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	11
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
8. Аудитын илрүүлэлт	13
8.1 Залруулсан алдаа.....	13
8.2 Зөвлөмж.....	13
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум

Цагаан Эрэг II баг

Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040

E-mail: Selenge@audit.gov.mn

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ
2022-03-15 № 007-2022/18-НА-СТА-ОНА

танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Цагааннуур тохижилт” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Цагааннуур тохижилт” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторовын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	17,035,620.72
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		17,035,620.72
1.1.1.1	Эргэлтийн хөрөнгийн дүн		17,035,620.72
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		-
1.2.1	Үндсэн хөрөнгө		
1.2.2	Биет бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн		-
1.3	Нийт хөрөнгийн дүн		17,035,620.72
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		-
2.1	ӨР ТӨЛБӨР		-
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		-
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг		-
2.1.1.3	Татварын өр		170,356.20
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн		170,356.20
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		-
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		-
2.2	Өр төлбөрийн нийт дүн		-
	ЭЗДИЙН ӨМЧ		-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг		16,865,264.52
2.3.11	Эздийн өмчийн дүн		16,865,264.52
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		17,035,620.72

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)		50,902,400.00
2	Борлуулалтын өртөг		25,942,443.28
3	Нийт ашиг (алдагдал)	-	24,959,956.72
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого		
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал		7,924,336.00
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-

17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		17,035,620.72
19	Орлогын татварын зардал		170,356.20
20	Татварын дараах ашиг (алдагдал)		16,865,264.52
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		16,865,264.52
23	Бусад дэлгэрэнгүй орлого		-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-
23.3	Бусад олз (гарз)		-
24	Орлогын нийт дүн		16,865,264.52
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2021 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	-	-	-		
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-		
2	Залруулсан үлдэгдэл	-	-	-		
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	16,865,264.52	16,865,264.52
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-		
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-		
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	
8	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	-	-	-	16,865,264.52	16,865,264.52

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн	-	50,902,400.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		50,902,400.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	-	-

1.2	Мөнгөн зарлагын дүн	-	33,866,779.28
1.2.1	Ажиллагчдад төлсөн	-	23,052,508.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	1,982,364.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-	3,263,000.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-	5,293,907.28
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	75,000.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-	-
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	-	200,000.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	17,035,620.72
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-	17,035,620.72
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	-	-
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	-	17,035,620.72

2.5 Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
2	Нийт орлого	м/төг	-	-	50,902,400.00	-	-
	Үүнээс: Цэвэр борлуулалт	м/төг	-	-	50,902,400.00	-	-
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	м/төг	-	-	-	-	-
3	Нийт зардал	м/төг	-	-	33,866,779.28	-	-
	Үүнээс: а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	м/төг	-	-	8,831,907.28	-	-
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	м/төг	-	-	25,034,872.00	-	-
	в) Хөрөнгө оруулалт их засвар	м/төг	-	-	-	-	-
4	Цэвэр ашиг, алдагдал	м/төг	-	-	17,035,620.72	-	-

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Цагааннуур тохижилт” ААТҮГ нь “Орон нутгийн өмчит нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, ногоон байгууламж, автозам, гүүр, цэвэр бохир, ус барилга, байгууламжийн ашиглалт, нэгдсэн халаалт дулаан үйлдвэрлэл, засвар үйлчилгээг стандартын дагуу үзүүлэх, хайрга хөрс үйлдвэрлэл, мод үржүүлэг байгуулах замаар сумын нийтийн үйлчилгээг хөгжүүлэх” гэсэн эрхэм зорилготойгоор тайлант онд үйл ажиллагаа явуулсан байна.

“Цагааннуур тохижилт” ААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын ундны усны худгийн хэвийн үйл ажиллагааг хангах, ус цэвэршүүлэх түгээх,
- Сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбайд хогийн сав байршуулах, хог хаягдлыг цэвэрлэх, ачиж тээвэрлэх,
- Сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбайд мод тарих, арчлах, хамгаалах шилжүүлэн суулгах,
- Мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг бүрэн хариуцах
- Сумын төвийн автозамын арчлалт,
- Золбин нохой устгал гэх мэт

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Цагааннуур тохижилт” ААТҮГ-ыг сумын ИТХТ-ийн 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 29 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд “Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх”, 18 дугаар зүйлийн 18.1.3 ж-д “Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, **дүрмийг батлах**”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ **орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих**” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс

шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,

- Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор “Айл өрхийн болон бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамж”-ийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс тооцож 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөх арга хэмжээг зохих журмын дагуу авч хэрэгжүүлэх,
- Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 242 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Цэвэр, бохир усны хэрэглээг зохицуулах түр журам”, “Төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөр тооцоог зохицуулах түр журам”-ууд,
- Сумын ИТХТ-ийн 2021 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Цагааннуур тохижилт” ОНӨААТҮГ-ын дүрэм,

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Цагааннуур тохижилт” ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн маягтаар гаргаж ирүүлснийг аудитын явцад аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн батлагдсан маягтаар тайлагнуулж, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлээ.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	17,035.6	
Бараа материал	-	-	
Үндсэн хөрөнгө	-	-	
Нийт хөрөнгө	-	17,035.6	
Өр төлбөр	-	170.3	
Хуримтлагдсан ашиг/+, алдагдал/-/	-	16,865.3	
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	-	17,035.6	

Банкин дахь харилцах дансны үлдэгдэл 17,035.6 мянган төгрөг нь усны төлбөрөөс төвлөрсөн орлого байна.

ААНБ-ын орлогын албан татварыг тооцож, барагдуулаагүйгээс богино хугацаат өр төлбөр данс 170.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт цэвэр ус түгээхтэй холбогдон гарсан худгийн засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл, цахилгаан, тээвэр шатахууны зардлуудыг хамруулсан байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Цагааннуур тохижилт” ААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Цагааннуур тохижилт” ААТҮГ-нь 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулалгүйгээр үйл ажиллагаа явуулсан бөгөөд гүйцэтгэлээр 50,902.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 33,866.8 мянган төгрөгийн зардал гарган, 16,865.3 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цагааннуур тохижилт аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар /цаашид Цагааннуур тохижилт ААТҮГ гэх/-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн аймгийн Засаг даргын 2021 оны А/58 тоот захирамжаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн жишиг заавар”-ыг мөрдөж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Одсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Цагааннуур тохижилт” ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Үйлдвэрийн газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө муутай гэж дүгнэж байна. Үүнд:

- 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, үйлдвэрийн газрын бүтэц, орон тоо, зохион байгуулалт, цалингийн болон бусад зардлыг төлөвлөж, холбогдох байгууллагаар батлуулаагүй,
- ТЕЗ-аас баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллаагүй,
- Үйлдвэрийн газрын тайлант жилийн үйл ажиллагааны үр дүнг холбогдох байгууллагад танилцуулж, үнэлэлт дүгнэлт өгөгдөөгүй байна.

“Цагааннуур тохижилт” ААТҮГ нь аймгийн ТЕЗ-ийн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж нягтлан бодох бүртгэлийг хөтлөөгүй учир цаашид дээрх бодлогын бичиг баримтыг мөрдөх, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналыг НББОУС-д нийцүүлэх шаардлагатай байна.

“Цагааннуур тохижилт” ААТҮГ-ын хувьд дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтангүй бөгөөд тайлант жилийн хугацаанд хяналт, шалгалт хийгдээгүй байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Цагааннуур тохижилт” ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын орлогын 50,902.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 1,018.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн болно.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

“Цагааннуур тохижилт” ААТҮГ нь 2021 оны 7 дугаар сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн боловч шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд цахим хаяг нээлгээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх “Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна. **3.1.1: Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд**” 7.1 дэх “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ”, 7.1.3: Тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд цахим хаяг нээлгэж, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасны дагуу шагнал урамшуулал олгоогүй, зочин төлөөлөгч хүлээн авах болон бэлэг дурсгалын зардал гаргаагүй байна.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд шинээр үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаа явуулсан тул өмнөх оны мэдээлэл байхгүй болно.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

“Цагааннуур тохижилт” ААТҮГ-ын ажилтнуудын цалин хөлсийг төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээгээр тогтоосон байна.

Цаашид дүрэмд заасны дагуу ажилтнуудын цалин хөлсийг үйлдвэрлэлийн үр дүнтэй уялдуулан тогтоож, холбогдох байгууллагаар батлуулан мөрдөж ажиллах шаардлагатай байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 26,112.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 26,112.7 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 2 зөрчилд албан шаардлага, 1 зөрчилд зөвлөмж өгөгдлөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 26,112.7 мянган төгрөгийн 2 алдааг залрууллаа. Үүнд:

- Орлогын дэлгэрэнгүй тайланд 170.3 мянган төгрөгийн орлогын албан татварыг нөхөн тооцуулж, татварын өр төлбөрөөр бүртгүүлж залруулав.
- Борлуулсан бүтээгдэхүүний өртгийг буруу хуваарилж, бүх зардал болох 25,942.4 мянган төгрөгийг удирдлагын зардлаар тайлагнасныг залруулав.

8.2 Албан шаардлага

1. Үйлдвэрийн газрын 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь “*үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах*” гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулж, мөрдөх албан шаардлага хүргүүлэх.

8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Аймгийн ТЕЗ буюу Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан “*Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг*”-ийг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж, ажиллаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь “*Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ..., мөрдөж ажиллана*” гэж заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

СЭА-2022/18-НА-СТА-ОНА

Өгсөн зөвлөмж: Аймгийн Засаг даргын 2021 оны А/58 тоот захирамжаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/																	
д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс								Хариуцлага тооцох		Зөвлөмж	
						Запруулга		Акт		Албан шаардлага							
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																	
1	“Цагааннуур тохижилт” ААТҮГ	СЭА-2022/18-НА-СТА-ОНА	Орлогын албан татвар тооцоогүй	1	170.3	1	170.3								-		
2	“Цагааннуур тохижилт” ААТҮГ	СЭА-2022/18-НА-СТА-ОНА	Борлуулалтын өртөг тооцоогүй	1	25,942.4	1	25,942.4								-		
3	“Цагааннуур тохижилт” ААТҮГ	СЭА-2022/18-НА-СТА-ОНА	2021 оны үйлдвэрлэлийн болон санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй.	1						1					-		
4	“Цагааннуур тохижилт” ААТҮГ	СЭА-2022/18-НА-СТА-ОНА	Аймгийн Засаг даргын 2021 оны А/58 тоот захирамжаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн жишиг заавар”-ыг мөрдөөгүй байна.	1										1	-		
ДҮН				4	26,112.7	2	26,112.7			1	-			1	-		
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																	
1	“Цагааннуур тохижилт” ААТҮГ	СЭА-2022/18-НА-СТА-ОНА	Шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд цахим хаяг нээлгээгүй							1	-		-				
ДҮН				1	-					1	-		-				
НИЙТ ДҮН				5	26,112.7	2	26,112.7			2	-		-	1	-		